



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/131/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Арвайхээр  
2022 он

Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253      Цахим хаяг: [BatjargalO@audit.gov.mn](mailto:BatjargalO@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833      Цахим хаяг: [GansukhD@audit.gov.com](mailto:GansukhD@audit.gov.com)

Аудитор: Р.Энхзул

Утас: 70323833      Цахим хаяг: [EnkhzulR@audit.gov.mn](mailto:EnkhzulR@audit.gov.mn)



## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Аудитын тайлан .....
- 3.1 Ерөнхий зүйл .....
- 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
- 3.4 Материаллаг байдал.....
- 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....
- 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....
- 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....
- 3.8 Аудитын гол асуудал.....
- 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
- 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
- 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
4. Аудитын илрүүлэлт.....
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕГ	Татварын ерөнхий газар

## 1. Аудитын дүгнэлт



### ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,  
Утас/Факс: (876) 7032 3253,  
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.02.14 № 147  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЭРДЭНЭСУВД ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>22,662,041.88</b>	<b>29,392,509.27</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>22,662,041.88</b>	<b>29,392,509.27</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>22,662,041.88</b>	<b>29,392,509.27</b>
35410	Бичиг хэргийн материал	2,031,401.00	7,942,100.00
35420	Аж ахуйн материал	20,630,640.88	21,434,129.27
35470	Бусад хангамжийн материал	0.00	16,280.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>387,492,459.04</b>	<b>365,910,636.22</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>387,492,459.04</b>	<b>365,910,636.22</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>362,292,459.04</b>	<b>340,710,636.22</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	131,991,830.00	131,991,830.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-21,488,803.87	-35,846,969.47
39203	Авто-тээврийн хэрэгсэл	129,800,000.00	149,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38,775,819.50	-58,372,281.25
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	213,523,976.46	239,769,790.34
39206	Хуримтлагдсан элэгдэл	-54,464,481.85	-87,595,670.55
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,607,657.73	14,607,657.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,901,899.93	-13,643,720.58
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>25,200,000.00</b>	<b>25,200,000.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	25,200,000.00	25,200,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>410,154,500.92</b>	<b>395,303,145.49</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>410,154,500.92</b>	<b>395,303,145.49</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>410,154,500.92</b>	<b>395,303,145.49</b>
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	<b>303,191,176.45</b>	<b>303,191,176.45</b>
51101	Өмч: - төрийн	303,191,176.45	303,191,176.45
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>83,445,922.39</b>	<b>68,344,566.96</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-65,794,520.20	83,445,922.39
51220	Тайлант үеийн үр дүн	149,240,442.59	-14,851,355.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	23,517,402.08	23,517,402.08
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>410,154,500.92</b>	<b>395,303,145.49</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,184,711,483.42</b>	<b>1,033,447,259.88</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>353,524,480.42</b>	<b>44,558,363.88</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>353,524,480.42</b>	<b>44,558,363.88</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	182,518,806.10	44,558,363.88
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	182,518,806.10	44,558,363.88
120009	Бусад орлого	171,005,674.32	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>831,187,003.00</b>	<b>988,888,896.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>821,085,003.00</b>	<b>942,463,896.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	821,085,003.00	942,463,896.00

**Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,102,000.00</b>	<b>46,425,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,102,000.00	46,425,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,035,471,040.83</b>	<b>1,048,298,615.31</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,035,471,040.83</b>	<b>1,048,298,615.31</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>964,963,979.83</b>	<b>929,369,936.03</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>574,789,557.00</b>	<b>628,204,732.64</b>
210101	Үндсэн цалин	383,948,292.00	420,949,597.00
210102	Нэмэгдэл цалин	110,202,896.00	90,703,340.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,621,751.00	44,410,000.00
210104	Урамшуулал	64,016,618.00	72,141,795.64
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>72,004,200.00</b>	<b>82,396,364.33</b>
210201	Тэтгэврийн даатгал	49,022,461.11	57,233,699.56
210202	Тэтгэмжийн даатгал	5,767,354.46	6,361,847.38
210203	ҮОМШ өвчний даатгал	4,603,802.30	5,049,157.82
210204	Ажилгүйдлын даатгал	1,146,418.99	1,250,150.93
210205	Эрүүл мэндийн даатгал	11,464,163.14	12,501,508.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>21,127,655.00</b>	<b>22,070,736.75</b>
210301	Гэрэл цахилгаан	3,078,952.00	2,922,496.75
210302	Түлш, халаалт	17,424,000.00	18,295,200.00
210303	Цэвэр, бохир ус	624,703.00	853,040.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>205,708,422.22</b>	<b>50,959,432.61</b>
210401	Бичиг хэрэг	6,093,800.00	10,946,571.00
210402	Тээвэр шатахуун	8,028,000.00	6,764,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	4,510,700.00	5,853,400.00
210404	Ном, хэвлэл	52,100.00	125,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	58,000.00	1,129,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	186,965,822.22	26,141,461.61
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,570,000.00</b>	<b>2,009,450.00</b>
210604	Урсгал засвар	1,570,000.00	2,009,450.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,079,600.00</b>	<b>5,044,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,079,600.00	5,044,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>46,306,647.00</b>	<b>68,393,383.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,878,030.00	62,969,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,400.00	159,328.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	4,568,755.00
210807	Газрын төлбөр	252,000.00	252,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	997,217.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>39,377,898.61</b>	<b>70,291,836.70</b>
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	4,172,799.00	2,464,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	35,205,099.61	67,827,636.70
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>70,507,061.00</b>	<b>118,928,679.28</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>67,646,421.00</b>	<b>64,976,083.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	60,913,651.00	56,576,083.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,732,770.00	8,400,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,860,640.00</b>	<b>53,952,596.28</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,860,640.00	53,952,596.28
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>149,240,442.59</b>	<b>-14,851,355.43</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>149,240,442.59</b>	<b>-14,851,355.43</b>

**Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	303,191,176.45	23,517,402.08	-65,794,520.20	0.00	260,914,058.33
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	303,191,176.45	23,517,402.08	-65,794,520.20	0.00	260,914,058.33
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	149,240,442.59	0.00	149,240,442.59
C08	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	303,191,176.45	23,517,402.08	83,445,922.39	0.00	410,154,500.92
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	303,191,176.45	23,517,402.08	83,445,922.39	0.00	410,154,500.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	303,191,176.45	23,517,402.08	83,445,922.39	0.00	410,154,500.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-14,851,355.43	0.00	-14,851,355.43
D09	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	303,191,176.45	23,517,402.08	68,594,566.96	0.00	395,303,145.49

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	831,187,003.00	988,980,249.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	831,187,003.00	988,980,249.00
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	821,085,003.00	942,463,896.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	821,085,003.00	942,463,896.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	10,102,000.00	46,425,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,102,000.00	46,425,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	0.00	91,353.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	91,353.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	824,128,003.00	968,980,249.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	824,128,003.00	968,980,249.00
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	753,620,942.00	849,960,216.72
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	574,789,557.00	628,204,732.64
210101	Үндсэн цалин	383,948,292.00	420,949,597.00
210102	Нэмэгдэл	110,202,896.00	90,703,340.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	16,621,751.00	44,410,000.00
210104	Урамшуулал	64,016,618.00	72,141,795.64
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	72,004,200.00	82,396,364.33
210201	Тэтгэврийн даатгал	49,022,461.11	57,233,699.56
210202	Тэтгэмжийн даатгал	5,767,354.46	6,361,847.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,603,802.30	5,049,157.82
210204	Ажилгүйдлийн даатгал	1,146,418.99	1,250,150.93
210205	Эрүүл мэндийн даатгал	11,464,163.14	12,501,508.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	21,127,655.00	22,070,736.75
210301	Гэрэл, цахилгаан	3,078,952.00	2,903,336.75
210302	Түлш, халаалт	17,424,000.00	18,295,200.00
210303	Цэвэр, бохир ус	624,703.00	872,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,702,500.00	27,989,900.00
210401	Бичиг хэрэг	3,579,900.00	6,560,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,028,000.00	6,764,000.00

**Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,510,700.00	5,853,500.00
210404	Ном, хэвлэл	447,600.00	433,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	62,300.00	1,129,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,074,000.00	7,250,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,609,000.00</b>	<b>2,800,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	2,609,000.00	1,800,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,079,600.00</b>	<b>5,044,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,079,600.00	5,044,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>45,313,430.00</b>	<b>76,134,628.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,882,030.00	70,279,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,400.00	159,328.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	5,000,000.00
210807	Газрын төлбөр	252,000.00	252,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,995,000.00</b>	<b>5,319,855.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,351,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,644,000.00	5,319,855.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>70,507,061.00</b>	<b>119,020,032.28</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>67,646,421.00</b>	<b>65,067,436.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	0.00	91,353.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	60,913,651.00	56,576,083.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,732,770.00	8,400,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,860,640.00</b>	<b>53,952,596.28</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,860,640.00	53,952,596.28
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>7,059,000.00</b>	<b>20,000,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>7,059,000.00</b>	<b>20,000,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>7,059,000.00</b>	<b>20,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>7,059,000.00</b>	<b>20,000,000.00</b>
223001	Бусад хөрөнгө	7,059,000.00	20,000,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-7,059,000.00</b>	<b>-20,000,000.00</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	942,463,900.00	942,555,249.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	942,463,900.00	942,555,249.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	885,887,800.00	831,935,216.72
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	673,190,700.00	628,204,732.64
210101	Үндсэн цалин	401,983,900.00	420,949,597.00
210102	Нэмэгдэл цалин	111,420,200.00	90,703,340.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	63,888,000.00	44,410,000.00
210104	Урамшуулал	95,898,600.00	72,141,795.64

**Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>90,786,700.00</b>	<b>82,396,364.33</b>
210201	Тэтгэврийн даатгал	63,859,100.00	57,233,699.56
210202	Тэтгэмжийн даатгал	6,731,900.00	6,361,847.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,385,500.00	5,049,157.82
210204	Ажилгүйдлийн даатгал	1,346,400.00	1,250,150.93
210205	Эрүүл мэндийн даатгал	13,463,800.00	12,501,508.64
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>22,070,800.00</b>	<b>22,070,736.75</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,903,400.00	2,903,336.75
210302	Түлш, халаалт	18,295,200.00	18,295,200.00
210303	Цэвэр, бохир ус	872,200.00	872,200.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,989,900.00</b>	<b>26,989,900.00</b>
210401	Бичиг хэрэг	6,560,000.00	6,560,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,764,000.00	5,764,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,853,500.00	5,853,500.00
210404	Ном, хэвлэл	433,400.00	433,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,129,000.00	1,129,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,250,000.00	7,250,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,800,000.00</b>	<b>1,800,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	800,000.00	800,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,044,000.00</b>	<b>5,044,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,044,000.00	5,044,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>60,685,700.00</b>	<b>60,109,628.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,254,300.00	54,254,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,400.00	159,328.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,000,000.00	5,000,000.00
210807	Газрын төлбөр	252,000.00	252,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,320,000.00</b>	<b>5,319,855.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	5,320,000.00	5,319,855.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>56,576,100.00</b>	<b>110,620,032.28</b>
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>53,952,596.28</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	53,952,596.28
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>56,576,100.00</b>	<b>56,667,436.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	0.00	91,353.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	56,576,100.00	56,576,083.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>942,463,896.00</b>	<b>942,463,896.00</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>942,463,896.00</b>	<b>942,463,896.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	942,463,896.00	942,463,896.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>46,425,000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>46,425,000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>38,025,000.00</b>
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0.00</b>	<b>1,000,000.00</b>
210402	Тээвэр, шатахуун	0.00	1,000,000.00

**Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	0.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	36,025,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	36,025,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	8,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	8,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	8,400,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.00</b>	<b>46,425,000.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	46,425,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	46,425,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Р.Энхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аймгийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 25 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс нь “Төсвийн орлого бүрдүүлэх, Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих” эрхэм зорилготой, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн орлогыг бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Тайлант хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ТЕГ-ын даргын 2020 оны 12 сарын 24-ний а/200 тоот тушаалаар татварын албаны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх журмыг баталсан байна.

Тус байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгжийн орон тоог 2020 оны 10 сарын 21-ний А/34 тоот тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд журмын дагуу дотоод хяналт шалгалтын жилийн ажлын төлөвлөгөөг батлуулан хараат бусаар хийгддэг.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 1048.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 10.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувь буюу 8.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө болон бараа материалын тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө оны эхнээс 46.2 сая төгрөгөөр өссөн нь худалдан авсан 20.0 сая төгрөгийн автомашин, ТЕГ-аас үнэ төлбөргүй ирсэн 26.2 сая төгрөгийн үнэ бүхий 13 ширхэг зөөврийн компьютер ирсэнтэй холбоотой байна.
- Бараа материал оны эхнээс 6.7 сая төгрөгөөр өссөн нь худалдан авсан бичиг хэргийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, ТЕГ-т нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 966.8 сая төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 821.5 сая төгрөгөөр батлагджээ.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайланд оны төсөв 821.5 сая төгрөгөөр батлагдаж, тодотголоор 121.0 сая төгрөгөөр нэмэгдэж 942.5 сая төгрөгийн санхүүжилт ирсэн ба үүнээс 2.8 сая төгрөгийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлжээ. Тайлант оны нийт төсвийн гүйцэтгэл 942.5 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөцөөс 21.7 сая төгрөгийг, Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газраас татварын гэрээний орлого 24.7 мянган төгрөгийг нийт 46.4 сая төгрөгийг санхүүжүүлэн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 36.0 сая төгрөгийг, тээвэр шатахууны зардалд 1.0 сая төгрөгийг, урсгал засварт 1.0 сая төгрөгийг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 8.4 сая төгрөгийг тус тус зарцуулжээ. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

### **3.8 Аудитын гол асуудал**

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэхэд шинээр худалдан авсан 0.2 сая төгрөгийн камерыг шууд зарлагадсан байсныг бараа материалын тайланд тусган залрууллаа. Гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардлаас 0.4 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан зөрчил илэрлээ.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс нь шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээлэл байршуулахаас 138 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 74.0 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага өгсөн бөгөөд биелэлтийг 2021 оны 05 сарын 12-ны өдрийн 101 тоот албан бичгээр ирүүлсэн.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй.

### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 0.7 сая төгрөгийн алдаа илэрсэн.

#### 4.1 Залруулсан алдаа

Шинээр худалдан авсан 0.2 сая төгрөгийн камерыг шууд зарлагадсан байсныг бараа материалын тайланд тусган залрууллаа

#### 4.2 Төлбөрийн акт

Акт тавигдаагүй.

#### 4.3 Албан шаардлага

Гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардлаас 0.4 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан зөрчилд албан шаардлага өгсөн.

#### 4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс									
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс	1	0.2	1	2.0								
2	Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс	1	0.4					1	0.4				

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Р.ЭНХЗУЛ